

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Сүмбэр сумын ЗДТГ”-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/35/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Чойр хот 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543156 Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Наранбаяр Утас: 70543179 Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Анхтуяа Утас: 70543179 Цахим хаяг: ankhtuyab@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	17
3.9 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт.....	18
4.1 Залруулсан алдаа	18
4.2 Төлбөрийн акт	18
4.3 Албан шаардлага	18
4.4 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
ГБХЗХГ	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ГХУСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,065,999,089.00	1,041,432,658.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,662,333.00	6,111,537.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,662,333.00	6,111,537.00
31210	Төгрөг	3,662,333.00	6,111,537.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	3,662,333.00	6,111,537.00
33	АВЛАГА	0.00	265,000.00
33500	Бусад авлага	0.00	265,000.00
33510	Байгууллагаас авах авлага	0.00	265,000.00
34	УРЬДЧИЛГАА	90,000,000.00	0.00
34200	Төсөвт байгууллага	90,000,000.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	948,124,756.00	999,925,121.50
35400	Хангамжийн материал	889,914,756.00	941,715,121.50
35410	Бичиг хэргийн материал	600,000.00	1,587,160.00
35420	Аж ахуйн материал	31,856,203.00	38,550,908.50
35450	Барилгын засварын материал	0	1,155,000.00
35470	Бусад хангамжийн материал	857,458,553.00	900,422,053.00
35600	Мал амьтад	58,210,000.00	58,210,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	24,212,000.00	35,131,000.00
36300	Тэжээлийн нөөц	24,212,000.00	35,131,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	939,363,670.01	945,826,965.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	939,363,670.01	945,826,965.04
39200	Биет хөрөнгө	889,107,836.79	895,921,131.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	529,168,567.24	539,168,567.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	-75,515,986.85	-97,154,766.69
39203	Авто-тээврийн хэрэгсэл	110,799,000.00	39,420,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-110,799,000.00	0.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	45,203,900.00	65,279,100.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-16,611,300.22	-29,146,561.52
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,840,260.00	74,779,260.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,981,603.02	-27,542,857.49
39214	Бусад үндсэн хөрөнгө	662,572,621.00	662,572,621.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-291,568,621.36	-331,454,230.68
39300	Биет бус хөрөнгө	50,255,833.22	49,905,833.18
39301	Програм хангамж	1,750,000.00	1,750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-634,166.78	-984,166.82
39303	Бусад биет бус хөрөнгө	49,140,000.00	49,140,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,005,362,759.01	1,987,259,623.54

“Сүмбэр сумын ЗДТГ”-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,200.00	372,205.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,200.00	372,205.50
41300	Өглөг	1,200.00	372,205.50
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,200.00	0.00
41360	Бусад өглөг	0.00	372,205.50
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	107,205.50
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	265,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,005,361,559.01	1,986,887,418.04
51	Засгийн газрын хувь оролцоо	2,005,361,559.01	1,986,887,418.04
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	786,753,176.71	786,753,176.71
51200	Хуримтлагдсан үр дүн	745,556,480.62	727,082,339.65
51210	Өмнөх үеийн үр дүн	432,796,652.44	745,556,480.62
51220	Тайлант үеийн үр дүн	312,759,828.18	-18,474,140.97
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	473,051,901.68	473,051,901.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,005,362,759.01	1,987,259,623.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,453,275,730.30	1,100,165,091.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	368,073,530.30	107,367,651.00
120	Нийтлэг татварын бус орлого	368,073,530.30	107,367,651.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,615,252.00	4,298,951.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,615,252.00	4,298,951.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	113,846,312.30	50,785,200.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	246,611,966.00	52,283,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,085,202,200.00	992,797,440.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	169,560,000.00	23,299,440.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	169,560,000.00	3,469,440.00

“Сүмбэр сумын ЗДТГ”-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	19,830,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	915,642,200.00	969,498,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	915,642,200.00	969,498,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,140,411,435.86	1,121,142,231.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,140,411,435.86	1,034,929,131.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,123,462,347.20	1,022,559,083.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	347,988,800.00	349,173,300.00
210101	Үндсэн цалин	231,418,900.00	252,695,200.00
210102	Нэмэгдэл	70,008,000.00	64,196,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,077,900.00	18,948,600.00
210104	Урамшуулал	0.00	10,763,350.00
210105	Гэрээт ажлын хөлс	29,484,000.00	2,569,950.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,777,431.19	50,752,431.36
210201	Тэтгэврийн даатгал	29,990,177.35	37,278,081.59
210202	Тэтгэмжийн даатгал	3,345,441.55	3,505,640.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,765,144.91	3,482,225.94
210204	Ажилгүйдлийн даатгал	591,167.38	959,217.02
210205	Эрүүл мэндийн даатгал	7,085,500.00	5,527,265.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,598,461.47	22,930,938.78
210301	Гэрэл, цахилгаан	3,261,841.47	3,809,881.30
210302	Түлш, халаалт	17,699,081.00	18,311,057.48
210303	Цэвэр, бохир ус	1,637,539.00	810,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	157,767,577.96	46,735,810.80
210401	Бичиг хэрэг	8,726,562.00	8,281,540.00
210402	Тээвэр, шатахуун	31,027,542.00	15,782,964.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,570,564.68	2,944,739.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,566,600.00	192,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	88,448,669.28	19,534,567.80
210408	Бараа материал акталсны зардал	20,427,640.00	0.00
2105	Нормативт зардал	294,700.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	294,700.00	0.00

“Сүмбэр сумын ЗДТГ”-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,629,010.00	5,651,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	90,000.00	0.00
210604	Урсгал засвар	15,539,010.00	5,651,600.00
2107	Томилолт, зочны зардал	9,785,000.00	5,913,000.00
210702	Дотоод албан томилолт	9,785,000.00	5,913,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	416,069,580.00	423,741,656.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	412,690,500.00	421,923,598.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,800,000.00	1,072,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	187,080.00	200,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	45,768.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	0.00	60,290.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	109,551,786.58	117,660,346.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,568,899.40	29,689,442.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	83,982,887.18	87,970,904.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,949,088.66	12,370,048.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,510,242.00	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,510,242.00	2,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,438,846.66	10,370,048.06
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,438,846.66	10,370,048.06
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	86,213,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	86,213,100.00
221001	Их засвар	0.00	86,213,100.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	312,864,294.44	-20,977,140.97
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	2,503,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	0.00	2,503,000.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	104,466.26	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	104,466.26	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	312,759,828.18	-18,474,140.97

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	786,753,176.71	438,171,701.68	432,796,652.44	1,657,721,530.83
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	786,753,176.71	438,171,701.68	432,796,652.44	1,657,721,530.83
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	34,880,200.00	0.00	34,880,200.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	312,759,828.18	312,759,828.18
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	786,753,176.71	473,051,901.68	745,556,480.62	2,005,361,559.01
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	786,753,176.71	473,051,901.68	745,556,480.62	2,005,361,559.01
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	786,753,176.71	473,051,901.68	745,556,480.62	2,005,361,559.01
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-18,474,140.97	-18,474,140.97
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	786,753,176.71	473,051,901.68	727,082,339.65	1,986,887,418.04

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,102,967,452.00	1,108,646,391.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,615,252.00	4,298,951.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,615,252.00	4,298,951.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,615,252.00	4,298,951.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,615,252.00	4,298,951.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,095,352,200.00	1,104,347,440.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	179,710,000.00	134,849,440.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	169,560,000.00	93,469,440.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,150,000.00	41,380,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	915,642,200.00	969,498,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	915,642,200.00	969,498,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,089,035,719.00	976,335,087.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,089,035,719.00	976,335,087.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	982,086,630.34	963,965,038.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	347,988,800.00	349,173,300.00
210101	Үндсэн цалин	231,418,900.00	252,695,200.00
210102	Нэмэгдэл	70,008,000.00	64,196,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,077,900.00	18,948,600.00
210104	Урамшуулал	0.00	10,763,350.00
210105	Гэрээт ажлын хөлс	29,484,000.00	2,569,950.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,776,231.19	50,753,631.36
210201	Тэтгэврийн даатгал	29,988,977.35	38,846,051.84
210202	Тэтгэмжийн даатгал	3,345,441.55	3,038,122.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,765,144.91	2,359,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	591,167.38	552,359.70

“Сүмбэр сумын ЗДТГ”-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	7,085,500.00	5,957,796.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,496,561.47	26,496,938.78
210301	Гэрэл, цахилгаан	3,261,841.47	3,809,881.30
210302	Түлш, халаалт	21,597,181.00	21,877,057.48
210303	Цэвэр, бохир ус	1,637,539.00	810,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	67,680,826.68	23,258,138.20
210401	Бичиг хэрэг	7,377,362.00	6,749,400.00
210402	Тээвэр, шатахуун	11,332,900.00	9,999,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,960,964.68	4,010,739.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	43,466,000.00	192,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	543,600.00	2,306,299.20
2105	Нормативт зардал	320,000.00	260,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	320,000.00	260,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,199,010.00	9,161,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	212,410.00	1,080,000.00
210604	Урсгал засвар	14,986,600.00	8,081,100.00
2107	Томилолт, зочны зардал	9,785,000.00	5,913,000.00
210702	Дотоод албан томилолт	9,785,000.00	5,913,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	425,487,380.00	424,114,656.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	422,108,300.00	422,296,598.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,800,000.00	1,072,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	187,080.00	200,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	45,768.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	0.00	60,290.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,352,821.00	74,834,274.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,352,821.00	74,834,274.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	106,949,088.66	12,370,048.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,510,242.00	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,510,242.00	2,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	94,438,846.66	10,370,048.06
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,438,846.66	10,370,048.06

213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	90,000,000.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	13,931,733.00	132,311,304.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	10,269,400.00	129,862,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,269,400.00	129,862,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,269,400.00	129,862,100.00
223001	Бусад хөрөнгө	0.00	86,213,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,269,400.00	43,649,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-10,269,400.00	-129,862,100.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,662,333.00	2,449,204.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	3,662,333.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,662,333.00	6,111,537.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан / төгрөгөөр /
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	969,498,000.00	964,370,699.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	969,498,000.00	964,370,699.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	967,498,000.00	962,370,699.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	349,173,300.00	349,173,300.00
210101	Үндсэн цалин	252,695,200.00	252,695,200.00
210102	Нэмэгдэл	64,196,200.00	64,196,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,948,600.00	18,948,600.00
210104	Урамшуулал	13,333,300.00	10,763,350.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	2,569,950.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,021,700.00	50,753,631.36
210201	Тэтгэврийн даатгал	39,255,200.00	38,846,051.84
210202	Тэтгэмжийн даатгал	3,442,300.00	3,038,122.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,753,400.00	2,359,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	688,200.00	552,359.70
210205	Эрүүл мэндийн даатгал	6,882,600.00	5,957,796.98

“Сүмбэр сумын ЗДТГ”-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,500,000.00	26,496,938.78
210301	Гэрэл, цахилгаан	4,000,000.00	3,809,881.30
210302	Түлш, халаалт	20,000,000.00	21,877,057.48
210303	Цэвэр, бохир ус	2,500,000.00	810,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,939,400.00	21,764,138.20
210401	Бичиг хэрэг	6,045,700.00	6,029,400.00
210402	Тээвэр, шатахуун	9,225,700.00	9,225,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,011,700.00	4,010,739.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	350,000.00	192,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,306,300.00	2,306,299.20
2105	Нормативт зардал	260,000.00	260,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	260,000.00	260,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,874,400.00	52,810,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,713,300.00	18,710,000.00
210602	Тавилга	25,000,000.00	24,939,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,080,000.00	1,080,000.00
210604	Урсгал засвар	8,081,100.00	8,081,100.00
2107	Томилолт, зочны зардал	8,321,600.00	5,913,000.00
210702	Дотоод албан томилолт	8,321,600.00	5,913,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	424,322,600.00	424,114,656.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	422,296,600.00	422,296,598.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,072,000.00	1,072,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	232,000.00	200,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	212,000.00	45,768.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	70,000.00	60,290.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,085,000.00	31,084,935.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,085,000.00	31,084,935.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00	2,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	969,498,000.00	964,370,699.94
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	969,498,000.00	964,370,699.94
320001	Орон нутгийн төсвөөс	969,498,000.00	964,370,699.94

61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	34.00	34.00
620001	Удирдах ажилтан	9.00	9.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр / Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	134,849,440.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	48,636,340.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	48,393,592.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,494,000.00
210401	Бичиг хэрэг	720,000.00
210402	Тээвэр, шатахуун	774,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,899,592.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,899,592.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,242,748.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,242,748.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	5,242,748.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	86,213,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	86,213,100.00
223001	Бусад хөрөнгө	86,213,100.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	134,849,440.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	134,849,440.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	93,469,440.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,380,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Сүмбэр сумын ЗДТГ”-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдтэй холбоотой зөвлөмж өгөөгүй байна.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Анхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сүмбэр сумын ЗДТГ” нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/65 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

“Сүмбэр сумын ЗДТГ”-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: Төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал: Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам", Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" тус тус шинэчлэгдэн батлагдсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүү, хяналт аудитын алба 2021 онд “Сүмбэр сумын ЗДТГ”-ын санхүүгийн болон шилэн дансны үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Сүмбэр сумын ЗДТГ” нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 1,140,411.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 11,404.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0 хувиар буюу 8,553.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

“Сүмбэр сумын ЗДТГ”-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,103.1 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, Засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,662.3	6,111.5	2,449.2
Авлага	0.0	265.0	265.0
Урьдчилгаа	90,000.0	0.0	-90,000.0
Бараа материал	972,336.7	1,035,056.1	62,719.4
Үндсэн хөрөнгө	939,363.7	945,827.0	6,463.3
Нийт хөрөнгө	2,005,362.7	1,987,259.6	-18,103.1
Өр төлбөр	1.2	372.2	371.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,005,361.5	1,986,887.4	-18,474.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,005,362.7	1,987,259.6	-18,103.1

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 6,111.5 мянган төгрөг болж 2,449.2 мянган төгрөгөөр өссөн нь ахмадын санг нэмэгдүүлснээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 265.0 мянган төгрөг болж нэмэгдсэн нь өвсний авлага үүссэнээс шалтгаалжээ.

Урьдчилгаа дансны 90,000.0 мянган төгрөгийн эхний үлдэгдэл нь Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2020 оны 06 дугаар тогтоолоор 90,000.0 мянган төгрөгийг сумын гэрэлтүүлэг, тохижилтын ажилд зарцуулахаар шийдвэр гаргаж, тендер зарлагдаж амжаагүйн улмаас авлага үүссэн байсан ба тайлант онд тендер зохион байгуулагдаж, гэрэлтүүлэг тохижилтын ажил хийгдэж, урьдчилгаа дансны үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,035,056.1 мянган төгрөг болж 62,719.4 мянган төгрөгөөр өссөн нь сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаас шалтгаалжээ. Бараа материалын данс нь урсгал төсвийн худалдан авалт 79,015.5 мянга, сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 51,348.5 мянга, бусад 935.0 мянга, нийт 131,299.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 68,579.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 945,827.0 мянган төгрөг болж 6,463.3 мянган төгрөгөөр өссөн нь урсгал төсвийн худалдан авалт, дахин үнэлгээнээс шалтгаалжээ. Тухайлбал, үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалт 43,649.0 мянга, АИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 41 дүгээр тогтоолоор лакаторын барилга 10,000.0 мянга, 39 дугаар тогтоолоор 3 автомашины үнийг дахин шинэчлэн тогтоож дахин үнэлсэн 39,420.0 мянга, бусад 1,365.2 мянга, нийт 94,434.2 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

АИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 39 дүгээр тогтоолоор 3 нэр төрлийн автомашин 110,799.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Өр төлбөр дансанд байгууллагад төлөх 372.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,986,887.4 мянган төгрөг болж 18,474.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

“Сүмбэр сумын ЗДТГ”-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 353,110.6 мянган төгрөгөөр буюу 24.3 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс үнэ төлбөргүй хүлээн авсан орлого болон нэмэлт санхүүжилтийн орлогод материаллаг өөрчлөлт гарсан байна.

Нийт зардал өмнөх оноос 19,269.2 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хангамж, бараа материалын зардал байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд өөрчлөлт ороогүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 923,413.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс бууруулаагүй 923,413.0 мянган төгрөгөөр баталсан байна. Төсөвт нэг удаа өөрчлөлт орж, 969,498.0 мянган төгрөг болж 46,085.0 мянган төгрөгөөр нэмэгдэж батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн “80101-Үндсэн үйл ажиллагааны зардал”, “80102-Туслах үйл ажиллагааны зардал”, “80106-Баг хорооны үйл ажиллагааны зардал” гэсэн нийт 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 969,498.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 969,498.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 969,498.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 964,370.7 мянган төгрөгийг зарцуулж, 5,127.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 964,370.7 мянган төгрөг буюу 99.5 хувь зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд өмнөх онд авлагад тооцон төвлөрүүлсэн 90,000.0 мянга, өвсний орлого 21,550.0 мянга, орцны хаалганы санхүүжилтийн орлого 17,990.0 мянга, ковид санхүүжилт 342.0 мянга, цахим тендерийн орлого 840.0 мянга, ГХУСЗ-ийн үйл ажиллагаанд 2,300.0 мянга, бусад орлого 1,000.0 мянга, нийт 134,022.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс өвс, тэжээл худалдан авах зардалд 21,550.0 мянга, талбайн тохижилтын зардалд 36,077.2 мянга, гэрэлтүүлгийн ажлын зардалд 49,308.5 мянга, орцны кодтой хаалганы зардалд 17,361.6 мянга, ГХУСЗ-ийн зардалд 2,300.0 мянга, сэг зэм устгах зардалд 1,000.0 мянга, бусад зардалд 1,182.0 мянга нийт 128,779.3 мянган төгрөгийг зарцуулж, 5,242.7 мянган төгрөгийн үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108, А/111 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцлон авч үзсэн.

3.8 Аудитын гол асуудал

Аудитад нөлөө үзүүлэх онцлох асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

“Сүмбэр сумын ЗДТГ” нь 2021 онд нийт 1,810,593.5 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 39,124.8 мянган төгрөгийн 4 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байна.

Иймд дээрх зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгч ажиллалаа.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 83,601.6 мянган төгрөгийн 14 алдаа зөрчил, илэрснээс, 63,277.3 мянган төгрөгийн 8 алдааг залруулж, 5,762.4 мянган төгрөгийн 3 зөрчилд 3 төлбөрийн акт, 14,561.9 мянган төгрөгийн 2 зөрчилд зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 1 зөрчилд 1 зөвлөмж өгсөн бөгөөд төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 100.0%-тай байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	5,762.4	3	5,762.4	-	-	-
Албан шаардлага	2	14,561.9	2	14,561.9	-	-	-
Зөвлөмж	1	0.0	1	0.0	-	-	-
Нийт дүн	6	20,324.3	6	20,324.3			

3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал

“Сүмбэр сумын ЗДТГ”-т анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 221,710.7 мянган төгрөгийн 10 алдаа зөрчил илэрснээс 156,978.3 мянган төгрөгийн 6 зөрчлийг завсрын аудитаар залруулж, 668.5 мянган төгрөгийн 2 зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 64,063.9 мянган төгрөгийн 2 зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын нийт 156,978.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд дараах залруулга хийгдсэн байна.

4.1.1 Завсрын аудитаар НДШ-д 4,294.1 мянган төгрөгийн өр төлбөртэй тайлагнасан байсныг зөвлөмж өгч залруулсан.

4.1.2. Завсрын аудитаар нярав бусад хангамж, мал амьтад, нөөцийн бараа материалын тайланг бэлтгээгүй байсныг зөвлөмж өгч залруулсан.

4.1.3 Завсрын аудитаар нярав үндсэн хөрөнгийн машин, тоног төхөөрөмж дансанд 1,100.0 мянган төгрөгийн хөдөлгөөн хийгдсэн боловч тайланг бэлтгээгүй байсныг зөвлөмж өгч залруулсан.

4.1.4 Ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээ бүрэн нөхсөн 110,799.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасахдаа дахин үнэлгээний хорогдол дансанд бүртгэсэн байсныг аудитын явцад залруулав.

4.1.5 Акталсан, дахин ашиглах боломжтой үндсэн хөрөнгийг 39,420.0 мянган төгрөгөөр дахин үнэлж дахин үнэлгээний нэмэгдэл дансанд орлого авсан байсныг аудитын явцад залруулав.

4.1.6 ГБХЗХГ-аас 1,365.2 мянган төгрөгийн үнэ төлбөргүй олгосон бараа материалыг тодруулга тайланд хандиваар хүлээж авсан гэж бүртгэсэн байсныг аудитын явцад залруулав.

4.2 Төлбөрийн акт

4.2.1 Ээлжийн амралтын олговрыг цалин хөлстэй давхардуулан 2 хүнд илүү тооцож 563.5 мянга, 3 албан хаагчдад дотоод журмын дагуу тэтгэмж, тусламж олгохдоо 105.0 мянган төгрөгийн ХХОАТ суутгаагүй нийт 668.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, 20.2.7, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар батлагдсан “Ээлжийн амралт олгох заавар”-ын 1 дүгээр хавсралтын 1, 22 дугаар зүйлийн 22.1.1, Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дугаар тушаалын хавсралтын 2.2 дахь заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3, 4.2.3.5-т заасны дагуу төлбөрийн акт хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.3 Албан шаардлага

4.3.1 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчиж 24,939.0 мянган

төгрөгөөр албан конторын тавилга худалдан авсан, нийт төсвийн дүнд 10 хүртэл хувийн хэмнэлт гаргаагүй зэрэг зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1, 1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.4, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ” дахь заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.3.2 Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5-н сая төгрөгөөс дээш зарлагын нийт 39,124.8 мянган төгрөгийн 4 гүйлгээ мэдээлээгүй зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.5, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.1.13, 3 дугаар зүйлийн 3.2.10 дахь заалтуудыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөөгүй байна.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сүмбэр сумын ЗДТГ	9	221,710.7	6	156,978.3	1	668.5	2	64,063.9	-	-